

## ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.10.15-10.19

## ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

**АНУ:** Энэ долоо хоногийн эхээр хувьцаат компаниудын 3-р улирлын санхүүгийн тайлан гарч зах зээлийн индексүүд өсч эхэлсэн бол, долоо хоногийн сүүлээр улс төрийн тодорхойгүй байдал хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

S&P 500 индексийн нийт зах зээлийн үнэлгээний 14%-ийг бүрдүүлдэг хувьцаат компаниудын тайлан гарсан байна. "Morgan Stanley" болон "Goldman Sachs" компанийн санхүүгийн тайлан эерэг үзүүлэлттэй гарснаар эдгээр компаниудын хувьцааны ханш өсчээ. Ингэснээр S&P 500 индекс мягмар гарагт 2.15%-аар өссөн үзүүлэлттэй байна. "Netflix" компанийн хэрэглэгчдийн тоо таамаг хэмжээнээс ихээр нэмэгдэж, тус компанийн хувьцааны ханш өслөө.

Дэлхийн эдийн засгийг тойрсон улс төрийн асуудлууд хувьцаат компанийн 3-р улирлын санхүүгийн тайлангаас илүүтэйгээр хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн байна. БНХАУ-ын юанийн ханшийн сулрал, Итали улсын төсвийн асуудал, Саудын Арабын Сэтгүүлч Жамаль Хашогги алга болсноор АНУ болон Саудын Арабын харилцааны тодорхой бус байдал зэрэг нь хөрөнгийн зах зээлд нөлөөлсөн байна. БНХАУ-ын юанийн ханш ам.долларын эсрэг сүүлийн 2 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн. Харин АНУ болон Саудын Арабын харилцааны цаашдын ирээдүй газрын тосны үнэд шууд нөлөөлөх боломжтой билээ.

АНУ-ын эдийн засгийн голлох үзүүлэлтүүд энэ долоо хоногт эерэг байлаа. 9-р сард тус улсын аж үйлдвэрийн түвшин таамаг хэмжээнээс ихээр нэмэгдэж, харин энэ долоо хоногт ажилгүйдлийн түвшин хамгийн доод цэгтээ хүрчээ.

**Европ:** Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд их хэлбэлзэлтэй байлаа. Санхүүгийн тайлагналын үе тохиосонтой холбогдуулан долоо хоногийн эхээр тус бүс нутгийн индексүүд өсөлттэй байв. Харин долоо хоногийн сүүлээр Итали болон Европын холбоо хоорондын харилцааны хагарал, Брексит хэлцлийн үр дүнгүй байдал, Испани улсын Дээд шүүхээс банкуудыг ипотекийн зээлийн татвар төлөхийг шаардсан шийдвэр зэрэг нь хөрөнгийн зах зээлд сөргөөр нөлөөлжээ.

Итали улс Европын холбооноос тавьсан төсвийн хязгаарлалтыг үл тоосноор тус улсын 10 жилийн хугацаатай Засгийн газрын бондын өгөөж сүүлийн 4 жилийн дээд түвшин буюу 3.73%-д хүрсэн байна.

Испанийн Дээд шүүх өөрийн банкууддаа ипотекийн зээлийн татвар төлөх шаардлага тавьснаар, банкуудын хувьцааны ханш буурчээ.

**Япон:** Японы хөрөнгийн зах зээлийн индекс уналттай хаагдлаа. Иенийн ханш ам.долларын эсрэг бага зэрэг чангарч 112.53 болжээ.

Япон улсын Сангийн яамны мэдээлснээр энэ оны 9-р сард нийт экспортын түвшин өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2%-аар буусан байна. Харин эдийн засагчид экспортыг 1.9%-аар өснө хэмээн урьдчилан таамаглаж байжээ. Энэ нь АНУ болон Хятад улс руу хийдэг тээвэрлэлт багассантай холбоотой хэмээн зарим шинжээчид үзэж байна.

**Эх сурвалж:** Reuters, Troweprice

### Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,437.97	0.05% ▲
Dow Jones	АНУ	25,444.34	0.41% ▲
S&P 500	АНУ	2,767.78	0.02% ▲
Nasdaq	АНУ	7,449.03	-0.64% ▼
S&P/TSX	Канад	15,470.10	0.36% ▲
FTSE 100	Их Британи	7,049.80	0.77% ▲
S&P/ASX 200	Австрали	5,939.50	0.74% ▲
Nikkei 225	Япон	22,532.08	-0.72% ▼
Hang Seng	Хонг Конг	25,561.40	-0.93% ▼

### Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	109.35
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	97.46
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	96.34
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	112.39
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.40
TDBM' 2020	USD	9.3%	105.65

### Зах зээлийн хүү

ХҮҮ	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	2.282	0.00 ▲
Libor 3M	2.477	0.04 ▲
Libor 6M	2.724	0.07 ▲
Libor 1YR	3.020	0.06 ▲
US 6M Bond	2.463	0.03 ▲
US 2YR Bond	2.904	0.06 ▲
US 3YR Bond	2.982	0.05 ▲
US 5YR Bond	3.048	0.04 ▲
US 10YR Bond	3.192	0.04 ▲

### Валютын ханш /төг/

Валют	2018.10.19	Өөрчлөлт
USD	2,564.24	0.02% ▲
CNY	369.86	-0.25% ▼
EUR	2,935.29	-1.27% ▼
RUB	38.99	0.33% ▲
KRW	2.26	0.00%
JPY	22.81	-0.09% ▼
CAD	1,964.18	-0.31% ▼

### Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,228.15	0.53% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	14.66	0.14% ▲
Зэс	USD/lb.	279.05	-0.80% ▼
Нүүрс	USD/MT	111.17	2.63% ▲
WTI газрын тос	USD/bbl.	69.25	-4.01% ▼
Brent газрын тос	USD/bbl.	79.9	-1.88% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	3.21	0.00%

### Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2018. IX	5.70%
Бодлогын хүү	2018. IX	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018. VIII	10.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	12.30%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018. VIII	5.10%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018. VIII	17.60%
Зээлийн дундаж хүү /валют/	2018. VIII	10.60%

**Эх сурвалж:** Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 42 компанийн 1,200.2 сая төгрөгийн 4,518,648 ширхэг хувьцаа арилжигдав.


“Алтайн зам” /AZH/ компанийн хувьцаа 52.04%-аар буюу хамгийн ихээр өсч 19,780 төгрөгт хүрч хаагдсан бол “Монгол савхи” /UYN/ компанийн хувьцаа 23.48%-аар буурч 505 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны зах зээл дээр нийт 120 ширхэг үнэт цаас 12 сая төгрөгөөр арилжаалагджээ.


10-р сарын 19-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,418.0 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,473.97 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.05%-аар өссөн байна.

## MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2018 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

## Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,212.2
Зах зээлийн үнэлгээ	2,417,999.6

## Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,437.97	0.05% ▲
MSE I индекс	9,796.84	0.05% ▲
MSE II индекс	8,879.18	-0.39% ▼

## Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
ЛэндМН ББСБ	3,522,131	252,160,756
Айтүүлс	361,845	44,725,979
Ард даатгал	239,581	194,578,532
Монгол базальт	69,298	22,213,296
АПУ	68,943	39,604,294

## Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Алтайн зам	19,780.00	52.04% ▲
Могойн гол	6,325.00	15.00% ▲
УБ-БҮК	382.00	13.35% ▲
Шивээ овоо	23,000.00	9.52% ▲
ЛэндМН ББСБ	74.17	5.81% ▲

## Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Монгол савхи	505.00	-23.48% ▼
Улаанбаатар хивс	13,500.00	-22.86% ▼
Силикат	120.00	-14.29% ▼
Стандарт ноос	300.00	-14.04% ▼
Хөвсгөл алтан дуулга	625.10	-10.70% ▼

## Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Мирэ Эссет Секьюритис Монгол	581,707,622
Голомт капитал	441,520,166
Ард секьюритиз	337,876,900
Стандарт инвестмент	217,269,229
БиДиСек	177,082,204

## Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	572.14	608,861
Таван толгой	7,800.00	410,789
Говь	33,460.00	261,026
МИК	10,970.00	227,181
Сүү	228.47	78,594

## ЗГҮЦ БОЛОН КОМПАНИЙН БОНДЫН АРИЛЖАА

ЗГҮЦ-ны анхдагч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZGEB-BD-15/08/20-A0295-14.5	15	1,500,000	100,000	100,000	156	14.500%
2	ZGEB-BD-20/06/20-A0260-15.14	105	10,500,000	100,000	100,000	156	15.140%

## НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Симбол	Компанийн нэр	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Нийт ногдол ашиг /сая төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.08.31	2018.09.10	2018.10.01-2018.11.30
2	ERS	Монгол алт	150.00	39.88	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
3	TEE	Тээвэр дархан	500.00	81.67	2018.04.27	2018.04.05	2018.12.31-ний дотор
4	TTL	Таван Толгой	2,410.00	126,923.13	2018.04.16	2018.04.03	2018.06.12-нд олгов
5	EER	Ариг гал	21.33	74.21	2018.04.25	2018.04.02	2018.09.01-с
6	BDL	Могойн гол	100.00	82.96	2018.04.26	2018.01.18	2018.06.26-нд олгов
7	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ	56.60	7.66	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
8	TAL	Талын гал	50.00	34.71	2018.03.05	2018.04.26	2018.12.31-ний дотор
9	BRC	Барилга корпораци	700.00	28.46	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
10	AND	Анд-Энерги	1.27	99.15	2018.02.24	2018.03.16	Тодорхойгүй
11	SUL	Жуулчин дюты фрий	10,000.00	653.62	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
12	GTL	Гутал	1,270.00	83.01	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
13	BNG	Баянгол зочид буудал	355.00	150.19	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
14	APU	АПУ	10.00	10,641.82	2018.02.19	2018.03.29	2018.05.17-нд олгов
15	BTG	Баянтээг	100.00	25.26	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
16	MIE	Материалимпекс	10.00	13.68	2018.02.19	2018.03.26	2018.04.17-нд олгов
17	HRD	Хүрд	497.00	67.23	2018.02.15	2018.02.23	2018.06.30-ны дотор
18	SUU	Сүү	3.00	1,032.00	2018.02.14	2018.04.05	2018.06.04-нд олгов
19	MNP	Монгол шуудан	3.68	366.48	2018.02.13	2018.04.13	2018.06.05-нд олгов
20	MMX	Махимпекс	100.00	380.07	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
21	TCK	Талх чихэр	170.00	174.03	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
22	GHC	Ган Хийц	100.00	24.25	2018.02.09	Тодорхойгүй	Тодорхойгүй
23	ADL	Адуун чулуун	130.00	409.67	2018.02.07	2018.03.01	2018.06.26-нд олгов
24	TAH	Тахь-ко	108.00	128.52	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
25	UBH	Улаанбаатар хивс	100.00	40.48	2018.02.05	2018.02.26	2018.05.01-с
26	GOV	Говь	220.00	1,716.25	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с олгов
27	HRM	Гермес центр	5.00	392.72	2018.01.24	2018.02.15	2018.04.12-нд олгов

## ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### “Ард даатгал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

“Ард даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 18/14 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 14:00 цагт хуралдуулахаар болсон тул хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хурлын тов: 2018 оны 12-р сарын 1-ний 14:00 цагт

Хуралдах газар: СБД, Амарын гудамж, Туушин зочид буудлын хурлын танхим

Бүртгэх өдөр: 2018 оны 10-р сарын 31-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, батлах;
2. Компанийн дүрмийг хэлэлцэж, батлах;
3. Дүрмийн санг нэмэгдүүлэх

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тогтоолын төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцахыг хүсвэл 2018 оны 12-р сарын 1-ний өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд СБД Амарын гудамж-2 Ард санхүүгийн нэгдэлийн байранд ирж танилцаж болно.

Холбоо барих утас: 7720-0088.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### МХБ: “Хүннү менежмент”, “Е Моние” компаниуд “All or none” дуудлага арилжаагаар хувьцаагаа санал болгож байна

МХБ-д бүгдийг нь биелүүлэх эсвэл үл биелүүлэх буюу “All or none” дуудлага худалдаагаар он гарсаар хоёр компани хувьцаагаа санал болгоод байна.

XI сард дуусах тус дуудлага арилжаанд МХБ-ийн III ангилалд бүртгэлтэй “Хүннү менежмент” болон “Е-моние” компаниуд хувьцаагаа санал болгоод байна. “Хүннү менежмент” компани нэгж хувьцааг 4,850 төгрөгөөр үнэлж нийт хувьцааныхаа 39.5 хувийг санал болгож байгаа бол “Е-моние” компани нэгж хувьцааг одоогийн ханшаас хоёр дахин өсгөж 2,550 төгрөгөөр үнэлэн нийт хувьцааныхаа 64.8 хувийг санал болгож байгаа талаар “Бумбат алтай” ҮЦК мэдээллээ. “All or none” дуудлага арилжаа нь ханшийн аль ч түвшинд биелж болдог. Энэ ч утгаараа “Хүннү менежмент” компанийн хувьцааны ханш хамгийн сүүлийн байдлаар 185 төгрөг байхад 4,850 төгрөгөөр санал болгож байгаа аж. Үүнээс өмнө буюу 2016 онд “Газар сүлжмэл” компани нийт хувьцааныхаа 66 хувийг “All or none” дуудлага арилжаагаар хөрөнгө оруулагчдад санал болгож байсан ч тухайн үед биелээгүй. Харин дараа нь багцын арилжаагаар тус компанийн 67 хувийг арилжиж, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд нь томоохон өөрчлөлт орсон. Ингэснээр компани нэрээ өөрчлөн “Жуулчин дюти фрий” болгон үйл ажиллагаагаа явуулж байгаа юм. Хамгийн сүүлийн байдлаар тус компанийн 70 гаруй хувийг “Таванбогд трейд” компани эзэмшиж байна. МХБ-ийн мэдээлснээр тус компани сүүлийн 5 жилд 2.4 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулагчдадаа ногдол ашиг хэлбэрээр тараасан байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Сүү” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн анхааралд

МХБ-ийн 1-р ангилалд бүртгэлтэй “Сүү” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Гантулга-ын гэрээний хугацаа дуусгавар болсон тул тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10-р сарын 05-ны өдрийн №11 тоот тогтоолоор түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, Тэргүүн дэд захирлын үүргийг гүйцэтгэж байсан М.Мандхайг Гүйцэтгэх захирлаар томилсон байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

### “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн хувьцааны дансны тухай зөвлөмж

Монголын хөрөнгийн биржид хандаж, үнэт цаасны данс нээлгэх, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн 1,072 ширхэг хувьцааг арилжаалах боломжтой эсэх асуудлаар тайлбар, мэдээлэл хүсч байгаа иргэдийн тоо ихээхэн нэмэгдэж байгаатай холбогдуулан Монголын хөрөнгийн биржээс энэхүү зөвлөмжийг гаргасан байна.

“Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монгол Улсын Их Хурлын 2010 оны 39 дүгээр тогтоол болон Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 98 дугаар тогтоол, 2012 оны 116 дугаар тогтоолуудаар иргэдэд үнэ төлбөргүй эзэмшүүлэхээр шийдвэрлэж, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 350 дугаар тогтоолын дагуу, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг түүний хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдэх хүртэл бусдад худалдах, шилжүүлэхгүй байхаар заасан байдаг. Өөрөөр хэлбэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид арилжаалагдаж эхлэх хүртэл бусдад шилжүүлэх, худалдах боломжгүй бөгөөд хөрөнгийн биржээр хувьцаа нь арилжаалж эхлэхийн тулд Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу “Эрдэнэс Тавантолгой” ХК нь нээлттэй хувьцаат компани хэлбэрээр Монголын хөрөнгийн биржид бүртгүүлсэн байх, Санхүүгийн зохицуулах хорооноос хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг өгсөн байх шаардлагатай юм.

Өнөөдрийн байдлаар “Эрдэнэс Тавантолгой” ХК нь хаалттай хувьцаат компани буюу Монголын хөрөнгийн биржийн үнэт цаасны бүртгэлд бүртгэгдээгүй, хувьцааны арилжаа эхлээгүй байгаа тул иргэд өөрийн эзэмшлийн “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг бусдад худалдах, шилжүүлэх боломжгүй байна.

Иргэд Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох, хувьцаа худалдах, худалдан авах зорилгоор үнэт цаасны данс нээлгэх эрх нь нээлттэй бөгөөд уг дансыг хөрөнгийн биржид бүртгэлтэй аливаа компанийн хувьцааны арилжаанд оролцох, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн биржид бүртгэгдсэний дараа арилжаалах үед ашиглана. Үнэт цаасны данс нээлгэсэн эсэхээс үл хамааран, “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн тохиолдолд иргэд ногдол ашгаа хүртэх эрхтэй байна. Иймд үнэт цаасны данс нээлгээгүй иргэд “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг эзэмших, ногдол ашиг авах, түүнийг бусдад арилжаалах эрхгүй гэх ташаа мэдээлэлд автахгүй байхад анхаарч, үнэт цаасны данс нээлгэх компанийг сонгохдоо тус компанийн үйлчилгээний чанар, хүртээмж, үнэ өртөг зэргийг харгалзан үзэж шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Монголын хөрөнгийн бирж нь “Эрдэнэс Тавантолгой” ХК болон гишүүн үнэт цаасны компаниудтай хамтран иргэдийг үнэн зөв, баталгаатай эх сурвалж бүхий мэдээ, мэдээллээр хангах ажлыг тогтмол зохион байгуулж байна.

**Эх сурвалж:** Монголын хөрөнгийн бирж

## ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

### Rio Tinto: III улиралд зэсийн баяжмалын гарц жилийн өмнөхөөс 7 хувиар өссөн

2018 оны III улиралд “Оюу толгой” ХХК-ийн зэсийн баяжмалын гарц өнгөрсөн оны мөн үеийнхээс 7 хувиар нэмэгдсэн байна. III улиралд компани 13,200 тонн зэсийн баяжмал үйлдвэрлэсэн бөгөөд оны эхний 9 сард нийт 39,400 тонн баяжмал үйлдвэрлэжээ. IX сарын эцсийн байдлаар Оюутолгой төслийн нийт ажиллах хүчний тоо 8,800 болсны 89 хувь нь монголчууд болохыг “Rio Tinto” компани мэдээллээ. Компани гүний уурхайн бүтээн байгуулалтын нийт зардлыг 5.3 тэрбум ам.доллар байна гэж тооцсон хэвээр байгаа бөгөөд 2020 оны дунд үе гэхэд анхны олборлолтоо хийхээр төлөвлөж байгаа аж. Хөрөнгө оруулалтын гэрээнд заасны дагуу 4 жилийн дотор буюу 2022 оны II сар гэхэд “Оюу толгой” ХХК дотоодоос эрчим хүчээ бүрэн авна гэж Засгийн газар найдаж байгаа. Одоогоор Монгол Улсын Засгийн газартай хэлэлцээгээ үргэлжлүүлж, судалгаагаа хийж байгаа гэж “Rio Tinto”-ийн тайланд дурдсан байна.

Эргэн сануулахад, “Тавантолгойд цахилгаан станц барихыг “Оюу толгой” компани зөвшөөрсөн. Гэрээний төслийг боловсруулах ажлаа эхэлж байна” гэж ЗГХЭГ-ын дарга Г.Занданшатар мэдэгдсэн. Тавантолгойн цахилгаан станцыг 4 жилийн хугацаанд барих боломжтой гэж Засгийн газар үзэж байгаа юм.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Хөвсгөл Алтандуулга: 1 га-аас авах ургац сүүлийн 6 жилийн дунджаас 36 хувиар нэмэгдлээ

Дотоодын улаан буудайн жилийн хэрэгцээ 320 орчим мянган тонн байдаг бол гурил үйлдвэрлэгчид ойролцоогоор 280 мянган тонн улаан буудай худалдан авдаг байна. Өөрөөр хэлбэл 170 орчим тэрбум төгрөгийн улаан буудайг худалдан авдаг ажээ.

Үүний 10 хувьд зээлийн хөнгөлөлт үзүүлэхэд 16.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцоолсон талаар ХХААХҮ-ийн сайд мэдээллээ. Мөн Тариалан эрхлэлтийг дэмжих сан зээлийн төлбөрт хүлээн авах улаан буудайг зэрэглэлээс хамаарч тариаланчдаас 520-600 мянган төгрөгөөр худалдаж авахаар болсон байна. Зээлийн төлбөрт суутгаж тооцох учраас гурилын үнэд өөрчлөлт орохгүй гэж албаныхан үзэж байгаа юм. Мягмар гарагийн байдлаар ургац хураалтын явц 73 хувьтай байгаа бөгөөд үр тариа, улаан буудайн дотоодын хэрэгцээг 100 хувь хангах боломж байна гэж үзэж байгаагаа ХХААХҮ-ийн сайд Б.Батзориг “Bloomberg”-д өгсөн ярилцлагынхаа үеэр онцоллоо.

Дотоодод үр тариагаа ургуулж, гурил үйлдвэрлэдэг “Хөвсгөл Алтандуулга” компани энэ хавар 3846 га талбайд улаан буудай тариалсан байна. Ургац хураалт 30 хоног үргэлжилж энэ сарын 14-нд 100 хувь дууссан талаар тус компани мэдээллээ. Нийт 600 га талбайн буудай цасанд даруулснаар ургац хураалт төлөвлөснөөс тав хоног илүү үргэлжилсэн байна. Хэдий тийм боловч тус компани байгаль цаг уурын хүндрэлээс урьтаж ихэнх талбайн ургацыг хурааж амжсан учраас бага хохирол хүлээсэн талаар мэдээллээ.

Нийт 5.8 мянган тонн улаан буудай хурааж га-ийн дундаж ургац 15.1 центнер болсон нь сүүлийн зургаан жилийн дунджаас 36 хувиар өндөр байгааг онцоллоо. “Хөвсгөл Алтандуулга” компани энэ жилийн улаан буудайн чанарыг сайн гэж дүгнэж байна. Мөн шинэ ургацын буудайн гурилаа зах зээлд нийлүүлж эхэлжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### Үнэт металлын сорьц тогтоох лаборатори Дархан-Уул аймагт нээгдлээ

Орон нутаг дахь алтны сорьц тогтоох, худалдан авах хоёр лабораторид Монголбанк, Швейцарын Хөгжлийн агентлаг, Стандарт хэмжил зүйн газар хамтран 700 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Алтны сорьц тогтоох, худалдан авах орон нутаг дахь анхны нэг цэгийн үйлчилгээний төвийг Дархан-Уул аймагт нээлээ. Лабораторийн бүтээн байгуулалтад зориулж Монголбанк, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран 395 сая төгрөгийн тоног төхөөрөмж хандивласан байна. Орон нутагт ийнхүү сорьц тогтоох лаборатори нээснээр алтны нийлүүлэлтийн сүлжээний албан бус шат дамжлага багасаж, Төв банкны алт худалдан авалт нэмэгдэх ач холбогдолтой гэж Швейцарын хөгжлийн агентлаг мэдээллээ. Энэхүү лабораторид нэг грамм алтыг 50 төгрөгөөр хайлуулна. Харин 1-100 грамм хүртэл жинтэй гулдмайг сорьцлоход 10 мянган төгрөгийн үнэтэй байх юм байна. Орон нутаг дахь дараагийн лабораторийг энэ сард Баянхонгор аймагт нээх товтой байна. “Цаашид хоёр аймагт нэмж сорьцын лаборатори байгуулах төлөвлөгөөтэй байгаа. Иргэд, аж ахуйн нэгж алтаа хайлуулж, сорьцлуулж орон нутаг дахь Монголбанкны хэлтэст тушаагаад мөнгөө дансандаа шилжүүлж авахад нэг цаг хангалттай” гэж Монголбанкны Ерөнхийлөгч Н.Баяртсайхан онцоллоо. Дархан, Сэлэнгийн бүс нутагт 20 гаруй аж ахуйн нэгж, 800 гаруй иргэн идэвхтэй алт олборлож жилдээ 2.9 тонн алтыг улсад тушаадаг гэж аймгийн удирдлагууд мэдээлж байна. Алт тушаасан үйлчлүүлэгчдийн зүгээс орон нутагт лаборатори нээгдэх нь цаг хугацаа хэмнэхээс гадна аюулгүй байдал хангагдаж байна гэж мэдээллээ.

Төв банк энэ онд худалдан авах алтныхаа хэмжээг өмнөх оны мөн үеэс 10 хувиар нэмэгдүүлж, 22 тоннд хүргэх зорилт тавьсан юм. Ингэснээр гадаад валютын албан нөөцийг 760 сая ам.доллараар зузаатгана гэж мэдээллээ. Харин 2019 оноос худалдан авах алтныхаа хэмжээг дахин хоёр тонноор нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа юм байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

### “Xanadu Mines” компани Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгүүлээ

Австралийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Xanadu Mines” компани Торонтогийн Хөрөнгийн биржид 10-р сарын 18-ны өдөр бүртгүүлсэн байна. Тус компани “ХАМ” гэсэн бүртгэлээр нийт 648 сая ширхэг энгийн хувьцаа, нэмэлтээр 96 сая ширхэг хувьцаа гаргаж байгаа талаар Торонтогийн Хөрөнгийн бирж мэдээллээ. “Xanadu Mines” компани Монголд “Хармагтай” ордод зэс, алтны хайгуул хийж байгаа бөгөөд 2018 онд хайгуулаа идэвхжүүлж, төсөл дээр өндөр эрдэсжилт бүхий “Зараа” талбайг олж илрүүлсэн юм. Одоогоор хайгуулын ажлаа үргэлжлүүлж байна. Үүнтэй холбоотойгоор “Хармагтай” ордын жорк стандартаар тогтоосон нөөцийг нэмэгдүүлэх боломжтой” гэж тус компанийн Гүйцэтгэх захирал Анджо Стюарт мэдэгдэж байсан юм.

IV улиралд танилцуулах эдийн засгийн урьдчилсан судалгаандаа шинэчилсэн нөөцийн дүн мэдээгээ хавсаргахаар тооцож байгаа аж. Ийнхүү “Xanadu Mines” компани “Хармагтай” төслийг хайгуулаас олборлолтын шат руу шилжүүлэхээр бэлтгэж байна. Санхүүгийн үзүүлэлтийг нь харвал тус компани өнгөрсөн 6-р сард хаалттай хүрээнд 29.4 сая ширхэг хувьцаа гаргаж, “Хармагтай” төслийн өрөмдлөгийн ажилд ашиглах 10 сая австрали долларын санхүүжилт татан төвлөрүүлжээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## БУСАД МЭДЭЭ

### Сүү ХК: Хувьцаа хуваасны дараа жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо 2 жилд 4 дахин өссөн

“Говь” компани хувьцааныхаа хөрвөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд нэгж хувьцааг 100 хуваах шийдвэр гаргаад байна. Хамгийн сүүлд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хөвсгөл Алтан дуулга”, “Дархан зочид буудал”, “УБ-БҮК”, АПУ болон “Сүү” компаниуд хувьцаагаа хуваагаад байна.

Эдгээрээс “Сүү” компани 2016 оны зургаадугаар сард нэгж хувьцаагаа 1000 хуваажээ. Долоо хоногийн хугацаанд арилжааны идэвх нь нэмэгдэж, 115 сая төгрөгийн хувьцаа арилжсан байна. Харин хувьцааны ханш нь энэ хугацаанд 8.1 хувиар унажээ. Хувьцаа хувааснаас хойш тус компанийн хувьцааны ханш хамгийн дээд тал нь 270 орчим төгрөгт хүрсэн бол сүүлийн байдлаар 224 төгрөг болоод байгаа юм. Хувьцаа хуваахаас өмнө буюу 2016 оны тавдугаар сард тус компанийн нийт хувьцааны 93.8 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, үлдсэн 6.2 хувийг 358 жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байжээ. Харин хамгийн сүүлийн байдлаар буюу энэ оны есдүгээр сард тус компанийн нийт хувьцааны 92.7 хувийг гурван том хувьцаа эзэмшигч, үлдсэн 7.3 хувийг 1568 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Өөрөөр хэлбэл тус компанийн жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо өнгөрсөн хоёр жилийн хугацаанд дөрөв дахин нэмэгдээд байгаа юм.

“Сүү” компани нэг өдөр АПУ компанийн хувьцааг 10 хуваасан байна. Хувьцааг хуваах үед хувьцааны арилжааны идэвх төдийлөн нэмэгдээгүй, хувьцааны ханш нь харьцангуй тогтвортой байжээ. Гэхдээ жижиг хувьцаа эзэмшигчдийн тоо нь нэмэгдсэн байна. Тодруулбал, хувьцааг хуваахаас өмнө тус компанийн 8.3 хувийг 3492 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшдэг байсан бол энэ тоо 2018 оны есдүгээр сард 5623 болж өсжээ. Харин жижиг хувьцаа эзэмшигчдийн мэдэлд байсан хувь хэмжээ буурч нийт хувьцааны 6.3 хувийг эзэмшдэг болсон байна.

Харин хувьцааг хуваасны дараа хувьцааны ханш нь хамгийн их хэмжээгээр өссөн компани бол “Хөвсгөл Алтан дуулга” компани байгаа аж. Хувьцааны ханш нь нэг сарын хугацаанд хоёр дахин өссөн байна. Энэ оны дөрөвдүгээр сард “Хөвсгөл Алтан дуулга” компанийн хувьцааны 78.4 хувийг хоёр том хувьцаа эзэмшигч, үлдсэн 21.6 хувийг 167 жижиг хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Харин есдүгээр сард том хувьцаа эзэмшигчдийн тоо нь нэмэгдэж тав болсноор 244 жижиг хувьцаа эзэмшигчид 20.9 хувийг нь эзэмшиж байгаа юм.

Хамгийн сүүлийн буюу есдүгээр сарын байдлаар хувьцаа нь арилжигдаж байгаа 200 гаруй компанийн дунд төвлөрөл өндөр байсаар байгааг Монголын Хөрөнгийн бирж мэдээлж байсан юм. Тухайлбал, бүртгэлтэй компаниудын 60 орчим хувийнх нь хөрвөх чадвар хангалтгүй, 32 компанийн арилжаа зогсоод байгаа ажээ.

**Эх сурвалж:** BloombergTv.mn



### WEF: Монгол Улс өрсөлдөх чадвараараа 140 улсаас 99 дүгээрт бичигдэв

“Дэлхийн эдийн засгийн форум” жил тутам гаргадаг дэлхийн улс орнуудын өрсөлдөх чадварын тайлангаа танилцууллаа. Монгол Улс өрсөлдөх чадвараар 2018 онд 52.7 нэгжийн үнэлгээтэйгээр 140 улсаас 99 дүгээрт бичигдсэн байна. Өнгөрсөн онд Монгол Улс 137 улсаас 101 дүгээрт жагсаж байжээ.

“Хөгжингүй орнуудын Төв банкнууд Мөнгөний бодлогоо илүү өндөр хурдаар чангатгаж байгаа, худалдааны маргаан даамжирч байгаа зэрэг нь Азийн хөгжиж буй орнуудын гаднын цочролд өртөмхий байдлыг нэмэгдүүлж байна. Тухайлбал, Монгол Улсын хувьд түүхий эдийн ханш доогуур байгаа нь өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна” гэж “Дэлхийн эдийн засгийн форум”-ын шинжээчид тайлбарлажээ. Тайлангийн гол үзүүлэлтүүд болох дэд бүтэц, боловсрол, санхүүгийн систем, инновацийн өрсөлдөх чадвараар хөгжиж буй орнууд хөгжингүй орнуудынхаас сул байгааг онцолсон байна. Хэдий тийм боловч Азийн хөгжиж буй орнуудаас Малайз, БНХАУ зэрэг орнууд нэлээд дээгүүрт буюу 25 болон 28 дугаарт жагсжээ.

Харин олон улсын хэмжээнд АНУ жагсаалтыг тэргүүлсэн байна. АНУ 100-аас 85.6 нэгж үнэлгээ авч, сүүлийн 10 жилд анх удаа жагсаалтыг тэргүүлжээ. Хэдий тийм боловч энэ нь Засгийн газрынх нь шинэ бодлогоос илүүтэй урт хугацааны үр нөлөө гэж судлаачид тайлбарлаж байна. Тус улсын бизнесийн орчин, санхүүгийн систем, инновацийн өрсөлдөх чадвараар өндөр үнэлгээ авчээ. Гэхдээ аюулгүй байдлын өрсөлдөх чадвараар харьцангуй доогуур үнэлгээтэй байгаа тул үүнийг цаашид ахиулах боломжтой гэж судлаачид үзэж байна.

Харин өнгөрсөн онд жагсаалтыг тэргүүлж байсан Швейцар гурван байраар ухарч, дөрөвдүгээрт бичигдсэн бол Сингапур, Герман, Япон улс эхний тавдугаарт багтсан байна. Өөрөөр хэлбэл эхний 30 байрт ихэвчлэн Ази, Европын хөгжингүй орнууд багтжээ. Африкийн орнуудын хувьд төдийлөн ахиц гараагүй гэж “Дэлхийн эдийн засгийн форум”-ын шинжээчид онцолж байна. Дэд бүлгээр нь задлаад харвал Герман улс инновацийн өрсөлдөх чадвараар нэгдүгээрт оржээ. Харин БНХАУ нэг хүнд ногдох худалдан авах чадварт суурилсан зах зээлийн хэмжээгээр тэргүүлсэн ч хэвлэлийн эрх чөлөөгөөр 140 дүгээр байрт буюу хамгийн сүүлд бичигдсэн байна.

**Эх сурвалж:** BloombergTv.mn

## МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.